



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/102

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны А/05 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Байтагзүр хайрхан” ХХК-ны гүйцэтгэсэн Багахангай дүүргийн “2 дугаар хорооны Улаан худгийг засварлах” болон Багахангай дүүргийн “ 2 дугаар хорооны Хадатын худгийг засаж хашаажуулах ажил”-ыг хүлээн авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд	Д.Хүрэлбаатар	Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	С.Ариунжаргал	2 дугаар хорооны хэсгийн ахлагч
Нарийн бичиг	П.Гарамрагчаа	“Байтагзүр хайрхан” ХХК-ны захирал

2. Ашиглалтад хүлээн авах ажлыг хууль, журмын дагуу чанар гүйцэтгэлд хяналт тавин зохион байгуулж эргэн танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Болормаа )-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД